

Шинжлэх ухааны туршилт ба амьтны эрхийн хамаарлын ёс зүйн асуудал

Д.Оюунгэрэл, доктор (Ph.D), дэд профессор
МУИС, Философи, шашин судлалын тэнхим
Г.Эрдэнэбаяр, доктор (Ph.D), дэд профессор
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Хураангуй: *Хэрэглээний ёс зүйн нэгэн салбар бол амьтныг хамгаалах ёс зүй бөгөөд хүн амьтны хоорондын, хүнээс амьтадтай хэрхэн харилцах асуудлыг судалдаг. Амьтныг хамгаалах ёс зүйн нэг гол асуудал бол амьтны эрхийн тухай ??? байдаг. Хүн төрөлхтөн өөрсдийн эрхийн талаар илүү сайн мэддэг, түүнийгээ хэрэгжүүлдэг ч амьтны эрхийн тухай асуудалд нухацтай хандах нь чухал юм. Амьтад ямар эрхтэй вэ? хэмээх асуулт төдий л шинэ содон биш боловч философи – ёс зүйн үүднээс тус асуудлыг чухалчлан авч үзэх шаардлага байсаар байна. Хүн урт наслах, амьдралын чанараа сайжруулахын тулд амьтдыг туршилтад оруулан ашигласаар байх нь зөв үү? гэдэгт тодорхой хариулт хэрэгтэй. Өнөөдөр шинжлэх ухааны туршилт судалгаанд амьтны туршилт бол энгийн үзэгдэл бөгөөд ялангуяа генетикийн инженерчлэл, ксенотрансплантаци, колончлол болон бусад асуудлын тоо нэмэгдсээр байгаа боловч туршилт судалгааг үргэлжлүүлэн ашиглах талаарх асуудал тавигдсаар ирсэн. Энэхүү өгүүлэлд амьтныг хамгаалах ёс зүйд амьтны эрхийг хамгаалах асуудлыг хэрхэн гаргаж тавьдаг, шинжлэх ухааны туршилтын үед амьтны эрх хэрхэн хөндөгддөг талаар авч үзнэ.*

Түлхүүр үг: ёс суртахуун, эрх, туршилтыг дэмжигчид, амьдралын чанар, өвдөлт

Амьтны эрхийн тухай олон янзын маргаан байдгийг бид мэднэ. Тэгэхээр энэ удаа бид шинжлэх ухааны туршилт нь амьтны эрхийг хэрхэн зөрчдөг тухай асуудлыг авч үзнэ. Юуны өмнө сэдэвтэй холбогдуулан дараах жишээнүүдийг нэрлэе. Тухайлбал, амьтныг туршилтад хамруулах аргачлалууд нь живүүлэх, хоолойг нь боох, хараагүй болгох, өлсгөх, түлэх, дүлийрүүлэх, тархийг нь гэмтээх, үе мөчөөр нь салгах, биенд нь төмөр таглаа тавих, дотор эрхтнийг нь бяцлах, зүрхний шигдээсийг зохиомлоор хийх, ходоодны шарх бий болгох, саажуулах, тархийг нь тогонд зохиулах, хүчээр тамхи татуулах, тамхины утаа үнэрлүүлэх, хүчээр архи, согтууруулах ундаа уулгах, төрөл бүрийн эм, хар тамхи тарих гэх мэт аргыг ашигладаг. Уламжлалт хандлагаар амьтдыг ашиглах нь ёс суртахууны хувьд хурц асуудал гэж ихэнх нь үздэггүй. Амьтад дээр туршилт хийх тухай асуудал нь эртний грекийн философич Аристотель нараас эхтэй гэдэг. Улмаар шинжлэх ухаан хөгжихийн хэрээр анатоми, физиологи, эмгэг судлал, эм судлалын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор амьд амьтад дээр туршилт хийж болж, өнөөдөр амьтад дээр туршилт хийх нь хэвийн зүйл болж, дэлхий даяар сая сая амьтдыг туршилтад хэрэглэсээр байна.

Физиологийн хувьд хүн амьтан хоёр бүх талаараа адил юм. Хүний тархи, нугасны гэмтэл нь харах, өвдөлт мэдрэх гэх мэт чадварыг бууруулахаас гадна ой санамжийг алдагдуулах тохиолдол бий. Дарвин физиологийн хувьд хүн амьтантай адил гэж дүгнэх нь зөв хэмээн үзэж байжээ. Хөхтөн амьтдын төв мэдрэлийн систем нь бүх талаараа хүнийхтэй төстэй байдаг ажээ. Хүн таашаал, өвдөлтийг мэдрдэг шиг нохой, гахай ч мөн мэдрдэг. Тиймээс таашаалыг мэдрэх, өвдөлтөөс зайлсхийх нь гайхах зүйл биш. Нэмж дурдахад, хүн болон хөхтөн амьтад айдас, уйтгар гуниг зэрэг янз бүрийн сэтгэл хөдлөлөө хуваалцахаас гадна туршлагаас суралцаж, өнгөрсөн үеэ дурсаж, ирээдүйгээ урьдчилан харж чаддаг (Darvin, 1976) ажээ. Эдгээр чадвар нь тэдний зан төлөвт нөлөөлдөг нь гайхах зүйл биш юм. Жишээлбэл, бусад хөхтөн амьтан урьд нь

ямар үйлдлийн үр дагавар нь тааламжтай эсвэл гунигтай байсныг санадаг тул биеэ авч явах арга замаа өөрчилдөг байна.

Ингэхлээр хөхтөн амьтдын сэтгэл зүйн нарийн төлөв байдал нь тэдний эрхийн талаар маргаан өрнүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Амьтад хэдий унших, бичих, ёс суртахууны сонголт хийх чадвар дутмаг нь үнэн ч тэд зовлон шаналлыг мэдэрдэг эсэх нь эрхийн тухай ярих хангалттай үндэслэл болно. Энэ тухай санааг баталж өгсөн философич бол утилитар ёс зүйн төлөөлөгч Ж.Бентам юм. Тэрээр “Тэд сэтгэж чадах уу? Тэд ярьж чадах уу? гэдэг нь сонин биш. Харин тэд зовлон мэдэрдэг үү? гэдэг нь чухал” (Rachels, 2015) хэмээсэн байдаг.

Амьтан дээр хийгдэж байгаа туршилт судалгааг үнэлэхэд ёс суртахууны гүйцэтгэх үүргийг авч үзэхгүй байгааг амьтны эрхийг хамгаалагчид асуудал болгон дэвшүүлдэг. Тэгвэл энэхүү бүтэлгүйтлийг ойлгох хамгийн сайн арга бол хүн дээрх туршилт болон хүний эрхийн зөрчил дэх аргуудыг орлуулан ойлгуулах, үүгээр дамжуулан амьтны эрхийг хамгаалах нь хичнээн чухал болохыг үндэслэх явдал юм. Өөрөөр хэлбэл, энэ асуултанд хариулах хамгийн сайн арга бол хүн дээр туршилт хийх бодит тохиолдлоос эхэлж ярих явдал юм.

Хүнийг зүй бус туршилтанд олон жилийн турш ашиглаж ирсэн. "Туршилтын туулай" болсон ихэнх хүн боловсрол эзэмшсэн, өөрсдийн эрхээ хамгаалах, түүнийгээ баталгаажуулж, хэрэгжүүлэх чадвартай байгаагүй. Харин бага насны хүүхэд (ялангуяа өнчин), өндөр настан, ял шийтгүүлсэн, хөгжлийн бэрхшээлтэй, ядуу, бичиг үсэг тайлагдаагүй аль эсвэл дайнд олзлогдогсод зэрэг нийгмийн эмзэг хэсгийнхэн байсан. Хүний эрхийг хамгаалагчид ийм зүйлийг хэзээ ч дэмжихгүй. Хүний бие махбод бүрэн бүтэн, айх айдасгүй амар тайван амьдрах эрх зэрэг нь ёс суртахууны хувьд зайлшгүй зүйл юм.

Орчин үеийн амьтныг хамгаалах ёс зүйн томоохон төлөөлөгч бол америкийн философич Том Реган амьтдыг ёс суртахууны хувьд эрхтэй хэмээн үзээд шинжлэх ухааны туршилтад амьтдыг ашиглахыг зогсоох, амьтны фермийн үйл ажиллагааг зохистой болгох, спортын зорилготой амьтдыг агнахыг зогсоох зэрэг хэд хэдэн зорилгыг биелүүлэхийн төлөө ажиллаж байжээ. Тэрээр шинжлэх ухааны туршилтыг амьтны эрхийг зөрчиж буй хамгийн том үйлдэл хэмээсэн. Том Реган амьтны эрхийг чухалчлахдаа хүний эрхийг хэрхэн дэмждэг тэрхүү үндэслэлээр авч үзэх ёстой хэмээн үзэж байв. Тэрээр хоёр үндсэн асуудлыг гаргаж тавьсан. Үүнд:

Нэгдүгээрт, тодорхой эрхийг эдлэх нь ёс суртахууны өвөрмөц төлөв байдлыг бий болгодог. Хүний эрх жинхэнэ утгаараа хэрэгждэг газар хүмүүс ёс суртахууны хамгаалалттай болсон байдаг. Нэг нь нөгөөгийнхөө бие махбодид гэмтэл учруулах, амь насыг нь хөнөөх, улмаар үхэлд хүргэх зэрэг ноцтой хохирол учруулахыг хориглосон "Орон зайд нэвтрэхгүй" гэсэн үл үзэгдэх “тэмдэг” үүргээ гүйцэтгэж байдаг (Cohen, 2014). Хэн нэгэн бусдын эрхийг зөрчвөл ёс суртахууны хувьд буруу зүйл хийж буйг бүгд мэддэг. Террористууд хүний эрхийг зөрчсөн үйлдэл гаргахад хэрвээ бид өөрсдийгөө хамгаалан зөрчил гаргагчдад ноцтой хохирол учруулж болзошгүй хариу арга хэмжээ авах үед бид эрхийнхээ хүрээнд ажилладаг. Эрхийг үндэслэл, шалтгаангүйгээр хэтрүүлэх нь ямагт эрх чөлөөт үйлдэл биш.

Хоёрдугаарт, бусдын бие махбодийн бүрэн бүтэн байдал, амьдрах эрхийг хүндэтгэх үүрэг нь бусад бүх үүргээс илүү юм. Нийтэд ашигтай байсан ч цөөнхийн эрх зөрчигдөх нь хүний эрхийг тууштай хамгаалагч хүний хувьд хүлээн зөвшөөрөх зүйл биш. Нийтийн сайн сайхныг дэмжих нэрээр хувь хүний эрхийг золиосолж болохгүй. Энэ нь бид эрхээ баталгаажуулж байна гэсэн үг. Хүн болж төрснийхөө хувьд эзэмшдэг ёс суртахууны үндсэн эрх нь амьтдад ч ялгаагүй чухал (Regan, 2001) хэмээн Том Реган үзжээ.

Амьтныг туршилтад оруулах нь:

- Мэдлэг олж авах

- Бүтээгдэхүүний аюулгүй байдлыг шалгах
- Анагаах ухааны буюу эрүүл мэндийг дээшлүүлэх зорилготой.

Энэ нь тухайн амьтанд бус харин “бусдад” хэрэгтэй мэдээлэл олж авах зорилготой байдаг. Учир нь туршилтанд орж байгаа амьтад ихэвчлэн хүнд гэмтэл авдаг нь тухайн амьтны тусын тулд биш юм.

Түүхэнд шинжлэх ухааны туршилтыг дэмжигчид, эсэргүүцэгчид байсаар ирсэн. Тухайлбал, туршилтыг ёс зүйн үүднээс дэмжих нэг чухал үндэслэл хэмээн тооцдог зүйл бол туршилтаас хүмүүс ашиг хүртэж ирсэн явдал юм. Хүний эрүүл мэнд сайжирч, урт удаан амьдрах боломж нэмэгдсээр ирсэн нь туршилтын үр дүн мөн. Үүнд: Зүрхний мэс засал, эрхтэн шилжүүлэн суулгах, төрөл бүрийн вакцин, нүдний болор суулгах хагалгаа, түнх шилжүүлэх хагалгаа, цус харвалт болон нуруу нугасны гэмтэлд өртсөн хүмүүсийн нөхөн сэргээх үйл ажиллагааг сайжруулах зэргийг дэвшил хэмээн юуны өмнө нэрлэж болно. Эдгээрээс гадна төрөл бүрийн өвчин эмгэгийг арилгах, байнгын хөгжлийн бэршээлтэй байдлаас салах, эрт үхэхээс сэргийлэх зэргийг ч мөн онцлон дурддаг. Үүнийг хүний үнэ цэнийг бусдаас дээгүүрт үнэлдэг антропоцентристууд дэмжинэ. Антропоцентрист үзэл баримтлалаар бүх зүйл хүний ашиг сонирхлыг дээшлүүлэхэд чиглэх ёстой байдаг. Жишээлбэл, амьтад бол хүн төрөлхтөнд хэрэгцээтэй тул хүнс тэжээл, анагаахын, сэтгэл санааны ач тусаар биднийг хангадаг. Зарим антропоцентрист үзэл баримтлалтай хүмүүс амьтад хэрэгцээгүй өвдөлт мэдрүүлэх нь муу зүйл хэдий ч хэрвээ тухайн зүйл хүнд хэрэгцээтэй тохиолдолд түүнийг хүлээн зөвшөөрөх ёстой хэмээн үздэг.

Тэгвэл антропоцентрист үзлийн эсрэг био төвт үзэлтнүүд “хүний асуудлыг биш, байгалийн асуудлыг чухалд тооцож, байгалийг хүндэтгэх нь юу юунаас илүү” (Barbara MacKinnon, 2018) хэмээн үздэг. Гол төлөөлөгч нь Альберт Швейцер (1875-1965), Поль Тейлор (1956-) нар бөгөөд байгалийн өмнө хүний хүлээх хариуцлагад гол анхаарлаа хандуулдаг. Хүний амьдралын чанарыг дээшлүүлэх нэг гарц болоод буй туршилт нь амьтны эрхийг зөрчдөг. Туршилтыг дэмжигчид амьтадтай зүй бус харилцаж, үл тоомсорлох байдлыг харуулдгийг тэд шүүмжилдэг. Гэвч туршилтын үеийн амьтдын нөхцөл, судалгааны үед учирч буй бэрхшээл, зовлонг тооцож үзэх ёстой. Мэдээж судалгаа амьтдыг зовоож байгааг ямар ч эрүүл хүн няцаахгүй.

Орчин үед амьтныг хамгаалах чиглэлээр төрөл бүрийн үзэл санаа, санаачлагууд гарч буйн нэг нь 3R-ийн зарчим юм. 1959 онд амьтан судлаач В.М.С.Рассел, микробиологич Р.Л.Бурч нар өөрсдийн номдоо танилцуулсан байдаг. 3R-ийн зарчим нь орлуулах (replacement), багасгах (reduction), сайжруулах (refinement) гэсэн утга бүхийн үгний товчлол юм. Тухайлбал, орлуулалт гэдэг нь амьтдын оронд эсийн өсгөвөр дээр туршилт хийх, компьютерийн загварыг ашиглах, эпидемиологийн судалгааг ашиглах зэргийг санал болгосон бол, багасгалт гэдэг нь туршилтанд ашигладаг амьтдын тоог бууруулах ёстой хэмээн үздэг. Тухайлбал, туршилтын техник, өгөгдөлд дүн шинжилгээ хийх арга техникийг сайжруулах, бусад судлаачтай мэдээлэл солилцох зэргийг нэрлэжээ. Аль нэг улсад хийсэн туршилтыг өөр улсын эрдэмтэд дахин хийхгүй байх, үүний тулд эрдэмтдийн хамтын ажиллагааг сайжруулах ёстой гэж тэд үзсэн. Харин сайжруулалт гэдэг нь амьтдыг арчлах арга замыг сайжруулахын тулд тэдний зовлонг дараах байдлаар бууруулна гэж үзсэн. Тухайлбал, эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах, амьдрах нөхцөлийг сайжруулах, зовлонг багасгахын тулд туршилтын процедурыг дасан зохицуулах гэх мэт болно.

Дэмжигчдийн орхигдуулж байгаа зүйл.

Аливаа мэтгэлцээнийг үр дүнтэй хийхийн тулд давуу болон сул талыг харьцуулан авч үзэх хэрэгтэй. Жишээлбэл, дан ганц өгөөжтэй талыг тодорхой гаргаж ирэх биш хохиролтой талыг ч гэсэн ижил хэмжээнд гаргаж ирэх ёстой. Дэмжигчид энэ асуудалд хоёр талыг зэрэг гаргаж ирж чадахгүй байна хэмээн амьтныг хамгаалах ёс зүйн төлөөлөгчид үздэг. Туршилтаас

хүмүүсийн учруулж байгаа хохирлыг үл тоомсорлож, хүн төрөлхтөнд ашиг өгч байгааг нь илүү ихээр гаргаж ирсэн. Мөн амьтдад хохирол учруулж буй байдалдаа дүгнэлт хийж, туршилтын арга барилаа өөрчлөх хүсэл бага байгааг анхаарууштай. Үүнд хэд хэдэн төрлийн алдаа байна.

Нэгдүгээрт, хүнд өгч байгаа үр ашгийг илүүд үзэх

Дэмжигчид шинжлэх ухааны туршилтгүйгээр хүний эрүүл мэндийн салбарт ахиц дэвшил гарахгүй хэмээн үздэг. Гэвч бодит байдал дээр баримт өөр зүйлийг хэлж байна. Нийгмийн эрүүл мэндийн судлаачид амьтад дээр хийгдэж байгаа туршилтыг нийгмийн эрүүл мэндэд өгөөж нь бага байдгийг онцолсон. Эрүүл мэндийн дийлэнх ололт амжилтын үр дүнд амьдралын орчин сайжирсан. Жишээ нь: Хувийн болон нийтийн эрүүл ахуй сайжирч, амьдралын хэв маяг өөрчлөгдсөнөөр хүний амьдралын чанар дээшилсэн тул амьтад дээр туршилт явуулахтай хамааралгүй.

Хоёрдугаарт, хүний учруулж байгаа хохирлыг орхигдуулах

Шинжлэх ухааны туршилт судалгаанаас амьтад хэмжээлшгүй их зовлон, өвдөлтийг мэдэрч, тахир дутуу болох, үхэл зэрэгтэй нүүр тулдаг. Зарим хохирол нь туршилтаас, зарим нь туршилтанд хориглосон зүйлээс үүдэлтэй. Жишээлбэл, хэрэглэгчдэд очихоос өмнө эмийг амьтан дээр тасралтгүй туршдаг.

Бидний мэдэж байгаагаар зарим эмийг амьтнаас хүнд хэрэглэхэд асуудал үүсдэг. Зарим тохиолдолд эм нь амьтанд хортой биш боловч хүнд хор болдог. Жишээлбэл, хүнд хор болсон эмийн буруу үр дагавраас болж америкийн зуун мянган иргэд нас барж, хоёр сая орчим хүн эмнэлэгт хэвтсэн байна (Cohen, 2014). Энэ нь америкчуудын хувьд цус харвалт, хавдар, зүрхний шигдээсийн дараа үхлийн шалтгааны дөрөвт бичигддэг. Ийм түүх байсаар байтал дэмжигчид нь энэ асуудлыг дурдахгүй орхигдуулж байна хэмээх шүүмжлэл түгээмэл байна.

Эмийн жорны эргэлт хариуцсан агентлагын мэдээлснээр “Эмч нарын зөвхөн 1 хувь нь эмийн сөрөг үр дагаврыг мэдээлдэг. Өөрөөр хэлбэл, 100 эмнээс гарсан буруу үйлдлийн 99 хувийг мэдээлдэггүй байна” (Cohen, 2014) Туршилтыг дэмжигчид нь үр өгөөжтэйг нь илүү байгааг батлахын оронд хохирол нь хэр их байгааг хүлээн зөвшөөрөх, зөв мэдээлэл түгээх хэрэгтэй. “Туршилт нь хориглосон зүйлээс их хэмжээний хор хохирлыг хүнд учруулдаг ажээ. Тамхи татах нь хавдрын нэг шалтгаан болдог. 1950 оноос хойш хавдрын судалгаанууд тамхи татах, уушигны хавдар тусах хоорондоо холбоотой гэж илрүүлсэн. Гэвч 50 гаран жилийн туршид олон удаагийн давталтаар амьтан дээр туршсан тамхины төрлийн судалгаагаар хавдар болсон үндэслэл байхгүй байжээ” (Cohen, 2014)

Гуравдугаарт, төрөл (хүн, амьтан) хооронд харьцуулах

Туршилтыг дэмжигчдийн нийтлэг алдаа нь төрөл хоорондын ялгааг их чухалчилдаг. Туршилт нь амьтанд хохирол учруулахаас илүүтэйгээр хүнд үр ашиг өгч байгаа гэдгийг чухалчлахдаа хүн амьтан хоёрыг харьцуулахад нэг нь нөгөөгөөсөө илүү гэдгийг хэрхэн яаж гаргах вэ? гэдгийг тайлбарлах хэрэгтэй. Жишээ нь амьтан дээр туршигдаж байгаа эм нь хүний биеийн өвчнийг анагааж байгаа тохиолдол болон тэр хэмжээгээр амьтдыг хэр их зовоож байгааг яаж тодорхойлох вэ? Америкийн философич Карл Коэний хэлсэнээр “Хүн төрөлхтний зовлон шаналал нь бусад төрлийн зовлон шаналлаас илүү чухал юм шиг байна” (Regan, 2001) гэжээ. Ер нь хүн зовлон шаналалгүй амьдрах хэдий чухал ч бусад амьтнаас илүү чухал гэж үзэх ёстой юу гэдэг асуудал бидний өмнө тавигдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл, “амьд бүхэн өвчин, зовлонгоос ангид байх эрхтэй” (Ч.Баярчимэг, 2020) тухай асуудал юм.

Дөрөвдүгээрт, туршилтын амьтдын амьдрах нөхцөл. Тухайлбал, хэт их бөөгнөрлөөс үүссэн стрессийг багасгахын тулд тэднийг байрлуулж буй байрыг эргэж харах ёстой.

Ашиг тусын маргаан: Хүний хувьд эрхийн тухай асуудал амьдралынх нь хамгийн чухал үнэт зүйл юм бол амьтдын хувьд жам ёсны эрхээ эдэлж, хүн үүсгэсэн зохиомол зовлонгоос

ангид байх эрхийг яагаад эдэлж болохгүй байна вэ? Хүнд ашигтай байх тухайгаас илүү тэд зовлон шаналалгүй амьдрах нь жинхэнэ ашиг тус юм. “Хүнд ашигтай” гэх үндэслэлээр амьтад дээр туршилт хийх нь ёс суртахууны хувьд зөв байж чадахгүй. Хүмүүсийн олж авч буй ашиг тус нь амьтдын эрхэнд халдаж, хор хөнөөл ихээр учруулж буй тул маргаанд зөв үндэслэл болж чадахгүй. Жишээлбэл, амьтдыг туршилтад оруулах нь хүнд ашиг тусаа өгдөг учраас тэдний амьдрах эрх чухал биш гэж үзэх нь өрөөсгөл болно.

Амьтныг хамгаалах ёс зүйд хүнд үр өгөөжтэй гэсэн шалтгаанаар туршилтыг дэмжих нь хангалтай зөв үндэслэл болж чадахгүй хэмээн үздэг. Тухайлбал, нэгдүгээрт анагаах ухааны судлаач, тэдгээрийг санхүүжүүлдэг хүмүүсийн туршилтын үзэл баримтлал ёсоор орлуулах байдлаар амьд бус туршилтын хувилбарыг боловсруулах нь шинжлэх ухааны хувьд хүчин төгөлдөр, өндөр үр дүнтэй байж чадахгүй байгаа тухай, хоёрдугаарт амьтад эрхтэй эсэх асуултад туршилтууд хүн төрөлхтөнд ямар их ашиг тусаа өгч байгаагаар хариулах явдал биш. Хүнд өгч буй ашиг тус хичнээн их байлаа ч амьтныг туршилтад ашиглан тэдний эрхийг зөрчсөн ёс суртахууны байдал бодитоор байсаар байгаа нь шударга бус юм.

Дүгнэлт

Энэ өгүүлэлд шинжлэх ухааны туршилт амьтны эрхийг зөрчдөг эсэх асуудлыг авч үзлээ. Мэдээж туршилтыг 100 хувь эсэргүүцэх учир дутагдалтай бөгөөд тухайлбал, амьтдыг боловсролын зорилгоор туршилтад ашиглах зарим арга нь боломжтой. Жишээлбэл, гэмтсэн амьтдыг эмчлэн байгальд нь буцааж тавихдаа тэдний зан авирыг ажиглах нь зөвтгөх үндэслэл болно. Өгүүлэлд тэмдэглэсэнчлэн шинжлэх ухааны мэдлэг олж авах, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг шалгах, анагаах ухааны гэсэн гурван үндсэн зорилгоор амьтдыг туршилтад ашигладаг. Эдгээрээс анагаах ухааны туршилтыг хүний эрүүл мэндэд чухал ач холбогдолтой тухай хандлагад анхаарч зөвтгөсөөр ирсэн. Гэвч “Хүнд ашигтай” гэдгийг үндэс болгож, амьтны эрх зөрчих нь буруу гэдгийг амьтныг хамгаалах ёс зүйн төлөөлөгчид илэрхийлсээр байгаа нь анхаарч үзэх зүйл мөн. Гоо сайхны бүтээгдэхүүн, химийн нэгдлийн хослол нь хүнд хор хөнөөл учруулахгүй болохыг тогтоохын тулд амьтдыг ашиглах үйлдлийг зөвтгөж боломгүй. Туршилтын амьтдын эрх хэрхэн зөрчигддөгөөс харахад туршилт нь ёс суртахууны хувьд буруу гэдэг нь нэгэнт тодорхой. Хүн төрөлхтөн туршилт хийх аргаа өөрчлөхгүйгээр "Өөр сонголт байхгүй" гэж хариулах нь асуудлыг үл тоомсорлосон хэрэг мөн. Хүмүүс туршилтаас олж буй үр өгөөжийг ёс суртахууны үндсэн дээр олж авдаг гэж үздэг боловч тийм биш байдагт бид дүгнэлт хийх ёстой.

Эцэст нь амьтны эрхийн талаар хүн төрөлхтний олонх нь антропоцентрист байр сууринаас хандаж, хязгаарлагдаж байгаа нь хүн-бус-амьтдын хэрэгцээ, ашиг сонирхол, хүсэл эрмэлзэл, эмзэг байдал, найдварын талаар ёс зүйн үүднээс тунгаан бодох нь чухал юм. Бидний хийж буй үйлдэлд ёс суртахууны үндэслэл хэрэгтэй бөгөөд ийм үндэслэл хэрэггүй гэвэл рационал дискурс өрнөх боломжгүй. Иймд хэчнээн таагүй, хувь хүний үзэл бодлоос зөрсөн байлаа ч философи үндэслэлүүдтэй танилцаж тунгаан бодох шаардлагатай.

Ном зүй

1. Barbara MacKinnon, A. F. (2018). *Ethics Theory and Contemporary Issues*. . Boston: CLDPC.
2. Cohen, A. I. (2014). *Contemporary Debates in Applied Ethics*. Oxford: Wiley Blackwell.
3. Darwin, C. (1976). *The Expression of the Emotions in Man and Animals*. London.
4. Rachels, J. (2015). *The Elements of Moral Philosophy*. New York : McGraw-Hill Education.
5. Regan, C. C. (2001). *The Animal Rights Debate*. California: Rowman & Littlefield Publishers.

6. Ч.Баярчимэг, М. Д. (2020). *Монголчуудын амьтныг хамгаалах ёс суртахууны уламжлал ба орчин үе*. Улаанбаатар : Тото пресс.

**Ethical consideration in relation to
scientific experiments and animal rights**

This article discusses the experiment on animals and animal rights. People sometimes think that all animal experiments serve vital medical purposes and can be justified on the grounds that they relieve more suffering than they cause. But nor can all experiments be defended on the grounds that they relieve more suffering than they inflict. It would therefore be better to develop other methods of research that do not make anyone, animal or human, suffer.